

ИНТЕРНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

20.. оны .. сарын ..-ны өдөр

№

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар Төмөр Зам” нийгэмлэг, түүнийг итгэмжлэлийн үндсэн дээр төлөөлж, УБТЗ-ын Бизнес Үйлчилгээний Рэйлком төв(цаашид **НИЙЛҮҮЛЭГЧ** гэх)-ийн захирал Д. Мөнхбуянт, нөгөө талаас (цаашид **ЗАХИАЛАГЧ** гэх)-ийг төлөөлж нар (цаашид хамтад нь **ТАЛУУД** гэх) Монгол улсын Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгон харилцан тохиролцож, үйлчилгээ үзүүлэх зорилгоор дор дурдсан нөхцлөөр энэхүү гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 **НИЙЛҮҮЛЭГЧ** нь **ЗАХИАЛАГЧ** байгууллагын хүсэлтийг харгалзан УБТЗ-ын шилэн кабелийн сүлжээг ашиглан 24 цагийн турш тасралтгүй Интернэтийн холболтын үйлчилгээг үзүүлэх, талууд тус гэрээгээр хүлээсэн эрх үүргээ хэрэгжүүлэн биелүүлэх, үйлчилгээний төлбөр бусад холбогдох тооцоог хийх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Гэрээ нь **ЗАХИАЛАГЧ** талаас өгөгдлийг оруулж, тухай бүрд баталгаажуулсан захиалгын хуудсын хамт хүчинтэй

ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 2.1 **НИЙЛҮҮЛЭГЧ** нь захиалгын хуудсанд заасан үнэ тарифын дагуу үйлчилгээг шуурхай үзүүлнэ.
- 2.2 Төлөвлөгөөт болон техникийн үйлчилгээг жилд 4-өөс доошгүй удаа 1 цагаас ихгүй хугацаанд хийнэ. Ажлыг гүйцэтгэхдээ 48 цагийн өмнө мэдэгдэж **ЗАХИАЛАГЧ**-ийн илүү тохиромжтой үед явуулах ба энэ хугацаа Үйлчилгээ тасалдсанд тооцогдохгүй.
- 2.3 **ЗАХИАЛАГЧ**-ийн гаргасан хүсэлтийн дагуу шаардлагатай техникийн хэмжилт, туршилтыг хийж өгнө.
- 2.4 **НИЙЛҮҮЛЭГЧ** нь техникийн болон холболтын шинэчлэлт хийх зэрэг зайлшгүй шалтгаанаар үйлчилгээгээр түр зогсоох шаардлага гарвал ажлын 2 хоногийн өмнө **ЗАХИАЛАГЧ**-д урьдчилан мэдэгдэж холболтыг түр хугацаагаар таслах эрхтэй бөгөөд бололцооны хэрээр тасалдалгүй, шуурхай, чанартай үйлчилгээг үзүүлнэ.
- 2.5 Гадаад операторуудын сүлжээнд гарсан гэмтэл саатал болон гуравдагч этгээдээс шалтгаалсан үйлчилгээний тасалдлын хохирлыг **НИЙЛҮҮЛЭГЧ** хариуцахгүй.
- 2.6 Сүлжээнд гэнэтийн осол гарсан үед **ЗАХИАЛАГЧ**-д урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авахгүйгээр засварын ажлыг эхлэх эрхтэй.
- 2.7 **ЗАХИАЛАГЧ**-ийн буруутай үйл ажиллагаанаас гарсан гэмтэл, түүний буруу (сүлжээнд зохицохгүй тоног төхөөрөмж холбох г.м) шийдвэрээс гарч болох сөрөг үр дагаврын хариуцлагыг **НИЙЛҮҮЛЭГЧ** хүлээхгүй ба энэхүү асуудлыг шийдвэрлэхэд гарах үйлчилгээний зардлыг гэмтлийн шалтгааныг тодруулсан актыг үндэслэн, **ЗАХИАЛАГЧ** төлж барагдуулна.
- 2.8 Гэрээг хэрэгжүүлэх явцад байгалийн гамшиг, дайн, хориг арга хэмжээ буюу түүнтэй адилтгах давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлээс хамаарсан гэмтэл, саатлын

хариуцлагыг **НИЙЛҮҮЛЭГЧ** хариуцахгүй.

ГУРАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 **ЗАХИАЛАГЧ** нь үйлчилгээг хүлээн авахад шаардлагатай өөрийн талын техникийн нөхцөл (тоног төхөөрөмж, холболтын интерфейс)-ийг бүрдүүлсэн байна.
- 3.2 **ЗАХИАЛАГЧ** нь үйлчилгээний талаар санал, гомдлоо илэрхийлэх эрхтэй.
- 3.3 **ЗАХИАЛАГЧ** нь үйлчилгээг зөвхөн өөрийн байгууллагын хэрэгцээнд, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэв хэмжээнд, интернэтийн нийтлэг стандартын дагуу хуулийн хүрээнд ашиглана. Буруу хэрэглээнээс үүдэн гарах хариуцлагыг **ЗАХИАЛАГЧ** бүрэн хүлээнэ.
- 3.4 **ЗАХИАЛАГЧ** нь **НИЙЛҮҮЛЭГЧ**-ийн зөвшөөрөлгүйгээр үйлчилгээг гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.
- 3.5 **ЗАХИАЛАГЧ** нь өөрийн компьютерийн дотоод сүлжээ, сервер компьютер болон сүлжээний нууцлал, хамгааллын асуудлаа бие даан хариуцна.
- 3.6 **ЗАХИАЛАГЧ** нь тухайн үйлчилгээтэй холбогдох шаардлагатай тусгай зөвшөөрлийн эзэмшигч байх ба олон нийтэд үзүүлж буй үйлчилгээний талаар үүсэх асуудлыг Харилцаа Холбооны Зохицуулах Хорооны өмнө дангаар хариуцна.

ДӨРӨВ. ТӨЛБӨР ТООЦОО

- 4.1 **НИЙЛҮҮЛЭГЧ** тал үйлчилгээний үнэ, тарифыг бизнесийн өрсөлдөөний дагуу өөрчлөх бодлогыг баримтлах ба энэ тухайгаа **ЗАХИАЛАГЧ**-д албан бичгээр мэдэгдэнэ.
- 4.2 Төлбөрийг тооцооны сараар авах ба энэ хугацаа нь хуанлийн сартай тэнцүү байна.
- 4.3 **НИЙЛҮҮЛЭГЧ** нь **ЗАХИАЛАГЧ**-ийн үйлчилгээний нэхэмжлэлийг тухайн сарын 10-ны өдрийн дотор гэрээнд заагдсан и-мэйл, факсаар илгээнэ. **ЗАХИАЛАГЧ**-ийн төлбөр тооцоо хариуцсан албан тушаалтны нэр, и-мэйл хаяг, утас, факсын дугаар өөрчлөгдсөн тохиолдолд **НИЙЛҮҮЛЭГЧ** талд албан бичгээр мэдэгдэнэ.
- 4.4 Гадаад операторуудтай хийсэн гэрээний заалтын дагуу **ЗАХИАЛАГЧ** нь сарын үйлчилгээний төлбөрийг **НИЙЛҮҮЛЭГЧ**-ийн нэхэмжлэхийн дагуу тухайн сарын 20-ны өдрийн дотор төлнө. Нэхэмжилсэн төлбөрийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд **НИЙЛҮҮЛЭГЧ** ажлын 3 хоногийн дотор сануулга өгөх ба үүний дараа ажлын 5 хоногийн дотор төлбөр хийгдээгүй бол үйлчилгээг зогсоох эрхтэй.
- 4.5 Захиалагч нь хугацаандаа төлбөрөө төлөөгүй тохиолдолд хэтэрсэн хоног тутамд 0,03%-ийн алданги төлөх ба нийт алдангийн хэмжээ нь гэрээт үнийн 50 хувиас хэтрэхгүй байна.
- 4.6 Тухайн сард гарсан гэмтэл, саатлын нийт хугацааг техникийн дүгнэлтийн үндсэн дээр акт үйлдэн тогтоож, үйлчилгээ тасалдсан хугацааны төлбөрийг ирэх сарын хураамжаас хасаж тооцно. Гэмтлийн актанд тухайн саатал гарсан шалтгаан, авсан арга хэмжээ, үргэлжилсэн нийт хугацаа болон үйлчилгээний төлбөрөөс хасч тооцох хугацаа зэргийг тодорхой зааж өгнө. Гуравдагч этгээдээс хамаарсан тасалдалтын хариуцлагыг **НИЙЛҮҮЛЭГЧ** хүлээхгүй.
- 4.7 **ЗАХИАЛАГЧ** нь захиалгын хуудсанд заасны дагуу нэхэмжилсэн төлбөрийг **НИЙЛҮҮЛЭГЧ**-ийн ХХБанк Төмөр Зам салбар 405012508 (төгрөгийн) дансанд шилжүүлнэ.

- 4.8 Үйлчилгээний гэрээ болон захиалгыг дуусгавар болгон цуцлах тохиолдолд анхны холболтын хураамж буцаан төлөгдөхгүй.

ТАВ. ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 5.1 Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсвэл зохих ёсоор биелүүлээгүйгээс нөгөө талдаа хохирол учруулбал буруутай тал хариуцлага хүлээнэ.
- 5.2 Талууд гэрээний үүргээ биелүүлэх явцад олж авсан гэрээтэй холбоотой мэдээллийн нууцыг задруулахгүй байх үүрэгтэй.

ЗУРГАА. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 6.1 Энэ гэрээнд заагдаагүй аливаа асуудлыг Монгол Улсад дагаж мөрдөж буй хууль тогтоомжоор зохицуулна.
- 6.2 Гэрээтэй холбогдон гарсан маргааныг талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд шийдвэрлэж чадахгүйд хүрвэл шүүхээр шийдвэрлүүлнэ.

ДОЛОО. ХУГАЦАА

- 7.1 Гэрээний хүчинтэй хугацаа 1 жил байна.
- 7.2 Хэрэв аль нэг талаас гэрээг цуцлах буюу дуусгавар болгох санал ирээгүй тохиолдолд гэрээг дахин 1 (нэг) жилээр сунгагдсанд тооцно.
- 7.3 Гэрээний хүчинтэй хугацаа дууссан ч Хавсралтаар баталгаажсан хугацаагаар гэрээ цаашид хүчинтэй үйлчлэх бөгөөд энэ талаар хоёр тал протокол үйлдэж, гэрээний хугацааг сунгана.

НАЙМ. ГЭРЭЭГ ӨӨРЧЛӨХ БУЮУ ЦУЦЛАХ

- 8.1 **ТАЛУУД** гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд санаачлагч **ТАЛ** ажлын 10 хоногийн өмнө албан бичгээр мэдэгдэж өөрчлөлт оруулна. Энэхүү өөрчлөлт нь **ТАЛУУД** гарын үсэг зурснаар баталгаажна
- 8.2 **ТҮРЭЭСЛЭГЧ** нь үйлчилгээний гэрээ болон захиалгыг дуусгавар болгон цуцлах тухай хүсэлт гаргах тохиолдолд 1 сараас доошгүй хугацааны өмнө албан бичгээр мэдэгдэнэ.
- 8.3 **ТҮРЭЭСЛЭГЧ**-ийн талаас захиалгын дагуу үйлчилгээг хүлээж авахаас өмнө захиалгыг дуусгавар болгон цуцлах хүсэлт гаргах тохиолдолд нэг сарын үйлчилгээний хураамжийг төлнө.
- 8.4 Энэхүү үйлчилгээний гэрээнд заагдсан хугацаанаас өмнө гэрээг цуцлах тохиолдолд цуцлах хүсэлт бүхий албан бичиг ирсэн өдрөөс тооцон 1 (нэг) сарын төлбөрийг төлнө.

ЕС. БУСАД

- 9.1 Энэхүү гэрээ нь **ТАЛУУД** харилцан гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.
- 9.2 Энэхүү гэрээ нь интернэтийн бөөний үйлчилгээний үндсэн гэрээ байх бөгөөд хавсралт захиалгын хуудас тус бүрийг **ТАЛУУД** баталгаажуулж, гарын үсэг зурж тамга дарсан байх шаардлагатай. Захиалгын хуудас нь энэ гэрээний салшгүй нэг хэсэг байна.

- 9.3 **ТАЛУУД**-ын инженер техникийн ажилтнууд үйлчилгээ эхэлсэн болон дуусгавар болсон тухай актыг тухай бүр үйлдэж баримтжуулсан байна.
- 9.4 Гэрээг 2 хувь үйлдэж **ТАЛ** тус бүр нэг, нэг хувийг хадгалах ба гэрээний хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна

ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ, БУСАД ӨГӨГДЛҮҮД:

УБТЗ-ын Бизнес Үйлчилгээний
Рэйлком төв

БГД, Тээвэрчдийн гудамж-8
Шуудангийн салбар – 35, Ш/Х-212

Утас: 242600
Факс: 252600

Маркетингийн хэлтэс:
Утас: 242601, 242879

24 цагийн инженерүүд:
Утас: 252525, 244693
И-мэйл хаяг: www.railcom.mn
Yahoo ID: noc_railcom

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“НИЙЛҮҮЛЭГЧ”-ийг төлөөлж:

.....

Д. Мөнхбуянт
Рэйлком төвийн захирал

“ЗАХИАЛАГЧ”-ийг төлөөлж:

.....

1. Захиалагч талын ерөнхий мэдээлэл

Байгууллагын нэр:

Харилцах хүмүүс:

Удирдлага:

Инженер, техник:

Санхүү, борлуулалт:

Утас:

Утас:

Утас:

И-мэйл хаяг:

И-мэйл хаяг:

И-мэйл хаяг:

2. Техникийн нөхцөл, хугацаа

Захиалгын хугацаа: **1 жил**

Техникийн мэдээлэл:

Сүлжээний Ай Пи (IP) блок хаяг	
Холболтын хурд (Mbps)	
Интерфейс	

Захиалгын төрөл: Шинээр☒

3. Интернэтийн бөөний үйлчилгээний ҮНЭ ТАРИФ

№	Бараа, үйлчилгээний нэр	Хурд (Мбит/с)	Нэгж үнэ (төг)	Нийт үнэ (төг)
1	Интернэтийн үйлчилгээ			
Нийт дүн				

Тайлбар

- Үйлчилгээнд холбогдсон өдрийг Талууд акт үйлдэн баталгаажуулах ба энэ өдрөөс эхлэн төлбөр тооцогдоно.
- ЗАХИАЛАГЧ тал захиалгыг цуцлах хүсэлтээ НИЙЛҮҮЛЭГЧ талд захиалгын үндсэн хугацаа дуусгавар болохоос 1 сараас багагүй хугацааны өмнө албан бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

ЗАХИАЛГЫГ БАТАЛГААЖУУЛСАН:

“НИЙЛҮҮЛЭГЧ”-ийг төлөөлж:

“ЗАХИАЛАГЧ”-ийг төлөөлж:

..... **Д. Мөнхбуянт**
Рэйлком төвийн захирал

.....

..... **Ж. Мөнхцэцэг**
Рэйлком төвийн ерөнхий нягтлан
бодогч

.....

20... оны ... сарын ...-ны өдөр

20...оны ... сарын ...-ны өдөр